

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН /2018 оны эхний хагас жилийн байдлаар/**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолд тусгаснаар Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээнд Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх; Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт бүхий 17 арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээний 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон тайлангийн хавсралтыг 4 дүгээр хүснэгтийн дагуу боловсруулав. Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын долоо дугаар бүлэгт заасныг баримталлаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан”-г нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилт хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж үнэлгээ, %
			100 ¹	70 ²	40 ³	0 ⁴	(-) ⁵	
- Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ - Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ	2	17	3	4	9	1	-	55.3

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2018 оны I улирлын байдлаар 9.4 хувьтай байснаа эхний хагас жилийн

¹ “үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь /90-100 хүртэл хувь/;

² “тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь /60-89 хүртэл хувь/;

³ “эрчимжүүлэх шаардлагатай” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31-59 хүртэл хувь/;

⁴ “үр дүнгүй” – зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь /0-30 хүртэл хувь/;

⁵ “үнэлэх боломжгүй” – зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан зэргийг баримтлан нотолсон бол.

байдлаар 55.3 хувьтай үнэлэгдсэн нь, 45.9 нэгж хувиар өссөн. Үүнд: 3 арга хэмжээ “үр дүнтэй”, 4 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 9 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 1 арга хэмжээ “үр дүнгүй”.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар					
			БТГ	МАА БХЗГ	ГТ БХЗГ	ХөҮ БХЗГ	ЖДҮХ БХЗГ	ХүҮ БХЗГ
Үүнээс	Үүнээс	Бүгд	1	4	5	4	2	1
		100%	-	2	-	1	-	-
		70%	-	-	2	-	1	1
		40%	1	2	2	3	1	-
		0%	-	-	1	-	-	-
	Үнэлэх боломжгүй	-	-	-	-	-	-	
Үнэлгээ			40.0	70.0	44.0	55.0	55.0	70.0

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Бодлого төлөвлөлтийн газар 1 арга хэмжээг 40.0, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4 арга хэмжээг 70.0, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5 арга хэмжээг 44.0, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 4 арга хэмжээг 55.0, Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 2 арга хэмжээг 55.0, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 70.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо
(салбараар, хяналтад авсан арга хэмжээ тус бүрээр)

№	Хариуцагч газар	№	Үйл ажиллагааны нэр	№	Шалгуур үзүүлэлт	II улирал/ 06 сарын 22	
						Үнэлгээ	Дунд аж
1	БТГ	1	3.1. Эрх зүй боловсруулах	10	5 баримт бичиг	40	40
2	МААБХЗГ, МЭҮГ, АДОБАЗ	1	2.1. Вакцинжуулалт	1	50 сая мал	100	70
		2	2.2.1. Цөм сүрэг хээлтүүлэгч ангилал	2	1000 мал	100	
		3	2.2.2. Эрчимжсэн МАА хөнгөлттэй зээл олгох	3	50-с цөөнгүй фермер	40	
		4	2.3. Бэлчээр нөөц судалгаа	4	35 га	40	
3	ГТБХЗГ	1	2.4.1. Атрын III аян	5	Аяны хэрэгжилт 30%	70	44
		2	2.4.2. Зоорь багтаамж нэмэх	6	7 000 тн.	70	
		3	2.4.3. Усалгаатай талбай	7	3000 га.	40	
		4	2.4.4. Т/төх шинэчлэл	8	Шинэчлэл хувь-75	40	
		5	2.4.5. Өвлийн хүлэмж	9	10 га.	0/20	
4	ХүҮБХЗГ	1	3.2. Эрүүл хүнс хөтөлбөр, мах-сүүний аян	11	Аяны хэрэгжилт 40%	70	70
5	ХөҮБХЗГ	1	3.3. “Үйлдвэржилт 21:100”	12	Хөтөлбөрийн хэрэгжилт 20%	40	55
		2	3.6. Ноолуур	15	Хөтөлбөр Хөтөлбөрийн хэрэгжилт 40%	40	
		3	3.7.1. Төрийн худал авалт	16	Худалдан авалт. өсөлт. хувь-10	40	
		4	3.7.2. Нэмэгдүүлэх нэр төрөл	17	Нэмэгдүүлэх нэр төрлийн тоо -10	100	
6	ЖДХБХЗГ	1	3.4. ЖДҮ төсөл зээл	13	Санхүүжүүлэх төсөл тоо-400	70	55
		2	3.5. “ЖДҮ...” хөтөлбөр	14	Хөтөлбөрийн хэрэгжилт 30%	40	

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл эхний улирлын байдлаар 9.4 хувьтай байснаа эхний хагас жилийн байдлаар 55.3 хувьтай үнэлэгдсэн хангалттай сайн үзүүлэлт юм. Өмнөх улирлаас 45.9, жилийн мөн үеийнхээс 14.2 хувь нэгжээр өндөр байна.

Улсын төсвийн хөрөнгөнөөс 192.35, гадаадын хөрөнгө оруулалтаар 106.0, хувийн хөрөнгө оруулалтаар 2.0, нийт 300.35 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Үүнээс эхний хагас жилийн байдлаар нийт төсөвлөсөн хөрөнгөөс 68.4-68.9 тэрбум төгрөг буюу ойролцоогоор 23 хувийг зарцуулаад байна.

Хүснэгт 4

№	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн хэмжээ, тэрбум төг.	Зарцуулалт, тэрбум төг.
1	Улсын төсөв	192.35	58.2-58.664
2	Гадаадын хөрөнгө оруулалт (2.4.4; 3.3)	106.0	10.2
3	Хувийн хөрөнгө оруулалт (2.4.5)	2.0	-
	Дүн	300.35	68.4-68.864 (23%)

Эхний хагас жилийн байдлаар үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг МААБХЗГ болон ХҮҮБХЗГ “үр дүнтэй”, бусад газар “эрчимжүүлэх шаардлагатай” хэмээн үнэлэгдсэн.

Өмнөх улиралтай харьцуулахад 17 зорилт, үйл ажиллагаанаас 15 (усалгаатай талбай, өвлийн хүлэмжээс бусад) –ын үнэлгээнд өөрчлөлт орж, нэмэгдсэн

Хүснэгт 5

№	Хариуцагч газар	№	Ажлын нэр	Үйл/а дугаар	I улирал/4 сарын 24		II улирал/6 сарын 22	
					Үнэлгээ	Дундаж	Үнэлгээ	Дундаж
1	БТГ	1	Эрх зүй	10	0/25	0	40	40
2	МААБХЗГ, МЭҮГ	1	Вакцин	1	40	10	100	70
		2	Хээлтүүлэгч	2	0/0		100	
		3	Хөнгөлттэй зээл	3	0/0		40	
		4	Бэлчээр нөөц судалгаа	4	0/10		40	
3	ГТБХЗГ	1	Атрын III	5	40	16	70	44
		2	Зоорь	6	0/10		70	
		3	Усалгаатай S	7	40		40	
		4	T/төх шинэчлэл	8	0/20		40	
		5	Өвлийн хүлэмж	9	0/20		0/20	
4	ХҮҮБХЗГ	1	Эрүүл хүнс Мах-сүү	11	40	40	70	70
5	ХөҮБХЗГ	1	21:100	12	0/20	0	40	55
		2	Ноолуур	15	0/0		40	
		3	Төр худал авалт	16	0/20		40	
		4	Нэмэгдүүлэх нэр төрөл	17	0/10		100	
6	ЖДҮБХЗГ	1	ЖДҮ төсөл зээл	13	0/30	0	70	55
		2	ЖДҮ хөтөлбөр	14	0/0		40	

I улирлын байдлаар дорвитой ажил хийгдээгүй, эхлүүлээгүй 7 зорилт, үйл ажиллагаа (2.2.1, 2.2.2, 2.3, 3.5, 3.6, 3.7.1, 3.7.2) байсан бол хагас жилийн байдлаар 1 арга хэмжээ (өвлийн хүлэмж) тэг үнэлгээтэй байна.

2018 онд хийгдсэн Үндэсний аудитын газрын аудиттай холбоотойгоор гарсан төлөвлөлтийн алдаа асуудал: УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан 2017 оны Үндсэн чиглэлд туссан, 3.2. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах” –заалт 2018 оны Үндсэн чиглэлд мөн тусгагдсан байгаа.

а) “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр (2018.06) одоогоор батлагдаагүй. 2017 онд тасарсан заалтыг хоёр жил дахь жилдээ тусгаж байна. (төлөвлөлтийн алдаа)

б) Дээрх хөтөлбөрийн төслийг Бодлого, төлөвлөлтийн газар болон Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын чухам аль нь тэргүүлж авч явах нь тодорхойгүй байна.

7. 2018 оны I улиралд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт хагас жилийн байдлаар 50 хувьтай байна.

Тав. Зөвлөмж

ХХААХҮ-ийн салбар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн нийт 17 арга хэмжээний гүйцэтгэл нь 55.3 хувь буюу зорилтот түвшнээсээ давсан үзүүлэлттэй гарсан тул үлдсэн хугацаанд бүх газар, харьяа байгууллага хүрсэн амжилтаа хадгалж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

“Үр дүнгүй” хэмээн үнэлэгдсэн нэг (2.4.5) үйл ажиллагаа нь төлөвлөлт бодитой бус, бэлтгэл ажил хангагдаагүй, үлдсэн хугацаанд тавьсан зорилтот түвшинд хүргэж, шалгуур үзүүлэлтэд хүрэхгүй, тасрах хамгийн өндөр магадлалтай байгаа тул хэрэгжилтэд анхаарал түлхүү тавьж эрчимжүүлэх шаардлагатайг;

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 70-аас доош хувьтай үнэлэгдсэн газар, хэлтэс зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй байдлыг ахнаарч, удирдлага, зохион байгуулалт, хариуцлага сайжруулах, үйл ажиллагаа эрчимжүүлэхийг

Үндсэн чиглэлд 2018 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвөөс 58.2-58.664, гадаадын хөрөнгө оруулалтаар 10.2 тэрбум төгрөг буюу төлөвлөгдсөн төсвийн 23 хувийн санхүүжилт хийгдсэн нь харьцангуй бага үзүүлэлт бөгөөд хувийн хөрөнгө оруулалт санхүүжилт одоогоор хийгдээгүй байгаа нь үндсэн чиглэлийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай тул хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийг;

Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хоёр жил дараалан тусгагдаад бүрэн хэрэгжээгүй байгаа эрхзүйн актыг яаралтай батлуулах, хэрэгжүүлэх төлөвлөгөө нэн даруй батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг;

Хүснэгт 5-д заасны дагуу зорилго, арга хэмжээ тус бүрээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

Хүснэгт 5

№	Хариуцагч газар	Үйл ажиллагааны нэр	№	Зөвлөмж
1	БТГ	3.1. Эрх зүй боловсруулах	10	Тайлагналтад ач холбогдол өгч ажиллах, эрчимжүүлэх
2	МААБХЗГ, МЭҮГ, АДОБАЗ	2.1. Вакцинжуулалт	1	Шинэ аргачлал, үйлчилгээний хөлсний урьд-гаа...
		2.2.1. Цөм сүрэг хээлтүүлэгч ангилал	2	МЭ-ийн байгуу-тай үйл ажиллагаа уялдуулах
		2.2.2. Эрчимжсэн МАА хөнгөлттэй зээл олгох	3	ГТ болон хот орчмын АА-г эрчимжүүлэх чиглэлээр анхаарах
		2.3. Бэлчээр нөөц судалгаа	4	2017 оны ҮЧ-д мөн 40-өөр үнэлэгдсэн. Энэ онд дээрхтэй ижил нөхцөл байдал ажиглагдаж байгаа тул эрчимжүүлэх шаардлагатай.
3	ГТБХЗГ	2.4.1. Атрын III аян	5	Томоохон ажил хийгдэж байгаа, төлөвлөгөө батлуулах
		2.4.2. Зоорь багтаамж нэмэх	6	Эрчимжүүлэх
		2.4.3. Усалгаатай талбай	7	Эрчимжүүлэх
		2.4.4. Т/төх шинэчлэл	8	Эрчимжүүлэх
		2.4.5. Өвлийн хүлэмж	9	Тасрах хамгийн өндөр магадлалтай зорилт, арга хэмжээ тул анхаарал хандуулж эрчимжүүлэх
4	ХҮҮБХЗГ	3.2. Эрүүл хүнс хөтөлбөр, мах-сүүний аян	11	БТГ ба ХҮҮБХГ-ын аль нэгэнд нь тусгайлан даатгаж эзэнжүүлэх
5	ХөҮБХЗГ	3.3. “Үйлдвэржилт 21:100”	12	Төлөвлөгөө батлуулах, санхүүжилт шийдүүлэх, эрчимжүүлэх, Тайлагналтад ач холбогдол өгөх
		3.6. Ноолуур	15	
		3.7.1. Төрийн худалдан авалт	16	Журмын 6 дугаар маягтаар мэдээг гаргаж улсын хэмжээний дүнг нэгтгэн хугацаанд нь гаргаж ирүүлэх
		3.7.2. Нэмэгдүүлэх нэр төрөл	17	
6	ЖДХБХЗГ	3.4. ЖДҮ төсөл зээл	13	Хамгийн багадаа 400 аж ахуй, иргэнд олгохоор тусгасан, төсөвт санхүүжилт бүгдийг олгохоор шийдвэрлэсэн байгаа
		3.5. “ЖДҮ...” хөтөлбөр	14	Хөтөлбөр яаралтай батлуулах

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2018 оны эхний хагас жилийн байдлаар)

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр		Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилт хувь
					Төлөв /тэрбум төгрөг/	Гүйц.сэн /тэрбум төгрөг/		
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО								
Зорилт 2. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ.								
1	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт МЭҮГ /Нэгтгэсэн мэргэжилтэн Д.Мөнхтуяа/	Малын халдварт, гоц халдварт болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Вакцинжуулалтад хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/	50-аас багагүй	20.0 Улсын төсөв	4.9 тэрбум төгрөг Улсын төсөв	Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 34.1 сая толгой мал хамруулахаас 2018 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 13.4 сая малыг хамруулж 39.3 хувь, гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад нийт 22.6 сая толгой мал хамруулахаар төлөвлөснөөс шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 10.0 сая толгой мэдрэмтгий малын 5.3 сая буюу 53.0 хувийг вакцинжуулсан байна. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 10.0 сая, хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 6.5 сая толгой малыг III улиралд хамруулахаар төлөвлөөд байна. Мал эмнэлэг үржлийн газар нь 2018 онд “Биокомбинат” ТӨААТҮГ-тай 20 нэрийн вакцин худалдан авах гэрээ байгуулснаар вакцины үйлдвэрлэл, шалгалтын явц 97.5, орон нутагт хүргэлт 76.1 хувьтай хэрэгжиж байна. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний календарчилсан ерөнхий төлөвлөгөөг 3000 ширхэг хэвлүүлэн аймгуудад тараасан. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Шадар сайдын 2018 оны 08 тоот тушаал гаргуулж, хавсралтаар Улсын онцгой комиссын гишүүд тус бүр нэг аймаг хариуцан ажиллах хуваарийг батлуулж, мөрдөн ажиллаж эхлээд байна.	100

2	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.33 дахь заалт	Бэлчээрийн монгол малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үүлдэр, омог, хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах, өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн малын тоог нэмэгдүүлэх	Шинээр нэмэгдүүлэх үржлийн цөм сүргийн өсвөр хээлтүүлэгч, малын тоо МЭҮГ	1000	0.3 Улсын төсөв	0.216	<p>-ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Малд үзлэг ангилалт хийх, бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх ажлыг гүйцэтгэх тухай” А/69 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор МЭҮГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/18 дугаар тушаалаар “Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийх хуваарь, ажлын удирдамж”-ийг батлав. Хуваарийн дагуу 16 аймгийн 54 сумын 369,1 мянган толгой малд үзлэг ангилалт хийж, анги чанарыг тогтоох бөгөөд үзлэг ангилалтаар цөм болон үржлийн сүргийн шаардлага хангасан малаас цөм сүрэг бүрдүүлж, үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчийг бойжуулах ажлыг хэрэгжүүлнэ.</p> <p>-Мал үржүүлэг, технологийн ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж буй үзлэг ангилалтад 6 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар хамрагдвал зохих малын 48 хувь болон 177,1 мянган толгой малыг ангилж бүртгээд байна. Мал үржүүлэг, технологи, үйл ажиллагаа нь бүс нутгийн онцлогоос шалтгаалан хугацааны хувьд харилцан адилгүй явагдах тул үзлэг ангилалтанд хамрагдсан малын тоо, анги чанарын үзүүлэлт болон өсвөр насны хээлтүүлэгч малын бодит тоо намрын ангилалтын эцэст бүрэн гарах болно.</p>	100 (эхний хагас жилд 184.55 мян. тол. малд хийхээс VI/19-ний байдлаар 96%-д хийсэн)
3			Хөнгөлөлттэй зээл авах фермерийн аж ахуйн нэгжийн тоо МААБХЗГ	50-аас багагүй	2.0 Улсын төсөв	0.294	<p>-2018 онд сүүний үхрийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжих зорилгоор 500.0 сая төгрөг батлагдсан. Мал хамгаалах сангийн эргэн төлөлтийн эх үүсвэрээр 6 сарын сүүлчээр төсөл сонгон шалгаруулалт зарлахаар бэлтгэж байна.</p> <p>-Эрчимжсэн аж ахуйн тэжээлийн үйлдэрлэл нэмэгдүүлэх зорилгоор "Уурагт таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх" төсөл зарлан 17 аж ахуйн нэгжийг сонгон 1.0 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гаргав.</p>	40

4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36, 2.38 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх МААБХЗГ	Отрын бүс нутгийн судалгаанд хамрагдах талбайн хэмжээ, га	35.0	0.05 Улсын төсөв	0	-Хөвсгөл аймгийн Баянзүрх, Цэцэрлэг сумын нутагт 87.0 мян. га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээнд авах судалгааг хийж холбогдох аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж гаргуулахаар ажиллаж байгаа бөгөөд засаг захиргааны анхан шатны (багийн ИНХ) байгууллагын дэмжсэн утга бүхий тогтоол гараад байна.	40
5	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.39-2.47, ЭЗСХ-ийн 2.1.8 дахь заалт	Атрын III аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх ГТБХЗГ	Аяны хэрэгжилт, хувиар	30.0	20.0 Улсын төсөв	Урамшуулал-14.8 (Мөнгөн хэлбэр-7.0 Мөнгөн бус 7.8) Буудайн Үр-4.0 тэрбум Техник-334,0 сая төгрөг, Жимс, жимсгэнэ хөтөлбөр-1.0 тэрбум, Хүнсний ногоо хөтөлбөр – 1.0 тэрбум төгрөг Нийт 21.1 тэрбум төгрөг	-Атрын III аяныг үргэлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр Засгийн газрын шийдвэрээр ой угтсан Атар-60 бүтээлч ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Тариалалтад зориулан 8.0 мянган тонн чанар сайтай элит болон сортын үрийн буудайг импортлон, шаардагдах 60.0 мянган тонн үрийн нөөцийг 100 хувь бүрдүүлэв. -Засгийн газрын шийдвэрийн дагуу тариалалтад олгох үрийн үнэнд хөнгөлөлт үзүүлж импортын 1 дүгээр үржүүлгийн болон элит үрийг 620.0-660.0 мянган төгрөгөөр, дотоодын ургацаас нөөц бүрдүүлсэн сортын үрийг 570.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож тариаланчдад 10-30 хувийн урьдчилгаатай зээлээр олгож намрын ургацаас нөхөн бүрдүүлэхээр шийдвэрлэн 611 аж ахуйн нэгж, иргэнд 30.5 мянган тонн буудайн үр олгов. - “Жимс, жимсгэнэ” Үндэсний Хөтөлбөрийн хүрээнд 2018 оны хавар 35 га-д тариалах 33000 ш үхэр нүд, 6900 ш бэсрэг алим, 5750 ш чавганы суулгацыг 22 аймаг, нийслэлийн жимс жимсгэнэ тариалагч иргэд, аж ахуйн нэгжид 10 хувийн урьдчилгаатай, 6 жилийн хүүгүй зээлээр олгож тариалуулав. -Хүлэмжийн ногооны 4 нэр төрлийн 33 кг үрийг 100.0 сая төгрөг, ил талбайн хүнсний ногооны 10 нэр төрлийн 23,691.7 кг үрийг 250.0 сая төгрөгөөр тус тус худалдан авах ажиллагааг зохион байгуулж аймаг, нийслэлийн ХХАА-н	70

						<p>газраар дамжуулан гарааны бизнесийг дэмжих, өрхийн тариаланг хөгжүүлэхэд зориулан олгов. Үүний үр дүнд 3100 га талбайд ногоо тарьж 37,0 мян.тн ургац хураан авна.</p> <p>-Улсын төсвийн 334,0 сая төгрөгөөр төмс үйлдвэрлэлийн зориулалттай 15 иж бүрдэл техник худалдан авах ажлыг зохион байгуулав.</p> <p>-Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. Булган, Сэлэнгэ, Төв аймгийн зарим сумдад нийт 400 гаруй км хашаа барих нээлттэй тендерийг зарлаад байна.</p>	
6			Зоорийн багтаамжийн нэмэгдэх хэмжээ, тн	7000	600	<p>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-30 дугаар тушаалаар Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд 100.0 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд 100.0 сая төгрөг, Ховд аймгийн Жаргалант суманд 400.0 сая төгрөгөөр 1200 тн хүнсний ногооны зорь байгуулахаар шийдвэрлэсэн. Тус ажлыг хэрэгжүүлэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны А/06/А/06 дугаар хамтарсан тушаалын дагуу Ховд аймгийн Жаргалант суманд 1.0 мянган тонн багтаамжтай түлхүүр гардуулах нөхцөлтэй хүнсний ногооны зорь байгуулах нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>-Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж техникийн саналыг үнэлээд байна.</p> <p>-Монгол банктай хамтран хэрэгжүүлсэн гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд зорь байгуулахаар хөнгөлөлттэй зээл авсан Органик солюшнс ХХК СХД-т 14.0 мянган тонн</p>	70

							багтаамжтай төмс хүнсний ногооны хагас автомат удирдлагатай, механикжсан зоорийг ашиглалтад оруулсан.	
7			Усалгаатай талбайг нэмэгдүүлэх хэмжээ, га	3000			<p>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх тухай 2018 оны А-30 дугаар тушаалаар Баян-Өлгий аймгийн Алтай сум, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумдад тэжээлийн таримал, хүнсний ногооны зориулалтын услалтын систем барихаар шийдвэрлэсэн.</p> <p>-Баян-Өлгий аймгийн Алтай сумын 22 га талбайг услах услалтын системийг сэргээн засварлах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас зарлан 6 сарын 11-нд тендерийн материалыг хүлээн авч сонгон шалгаруулах ажил явагдаж байна.</p> <p>-Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын “Тээлийн ам”-ын 95 га-ийн услалтын системийг сэргээн засварлах ажлын зураг төсөл хийх зөвлөх үйлчилгээний тендерийг аймгийн ЗДТГ-аас зарлан шалгаруулалт хийж ТЭЗҮ, зураг төсөл, төсөв батлагдсан. Барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер зарлахад бэлэн болсон.</p> <p>-БНХАУ-ын Засгийн газрын 16.9 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 50-125 га талбайг услах үр тарианы зориулалттай усалгааны тоног төхөөрмж 130 ширхэг, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг услах зориулалттай бага болон дунд оврын усалгааны тоног төхөөрөмж 126 ширхэг, 0,8-1,0 тpa даралттай усалгааны хуванцар хоолойг нийлүүлэх гэрээ байгуулсан “Foton Iovol” ХХК-ны ирүүлэн урьдчилгаа санхүүжилт хүссэн бичиг баримтыг Сангийн ямаар дамжуулан БНХАУ-ын Экзим банкинд хүргүүлж 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Үүний үрд 256 иж бүрдэл усалгааны тоног төхөөрөмж</p>	40

							нийлүүлэгдэж 10000 га талбайн үр тариа, 770 га талбайн төмс, хүнсний ногоо, 150 талбайн жимс, жимсгэний талбай услах техникийн чадамжтай болох юм.	
8			Тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувь	75.0	6.0 Гадаад эх үүсвэр		-Монгол Улсын Хөгжлийн банкны дэргэдэх “Ди Би Эм Лизинг” ХХК-тай хамтарч ОХУ-ын Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 18 нэр төрлийн 209 тооны техник, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна. “Ди Би Эм Лизинг” ХХК нь ОХУ-ын техник үйлдвэрлэгч 3 аж ахуйн нэгжтэй нийт 4.7 сая еврогийн хөдөө аж ахуйн зориулалттай 16 нэр төрлийн 166 ширхэг техник, тоног төхөөрөмж зээлээр нийлүүлэх гэрээг байгуулаад байна. Төслийг хэрэгжүүлснээр үр тарианы техникийн шинэчлэл 75 хувьд хүрнэ.	40
9	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.44, ЭЗСХ-ийн 2.1.13 дахь заалт	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах ГТБХЗГ	Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, га	10	2.0 Хувийн хөрөнгө оруулалт		-Өвлийн хүлэмжийн аж ахуйн шөнийн цахилгааны тарифыг 10 дугаар сарын 15-наас 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 22 цагаас 06 цагийн хооронд 100 хувь хөнгөлөх, төвийн дулааны төлбөрийг 50 хувь хөнгөлөх, “Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөл хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан яамдуудаас санал авч дуусч байгаа ба 7 сард Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байна. Үүний үр дүнд өвлийн хүлэмжийн талбай 20-50 га-аар нэмэгдэх ба үйлдвэрлэл өсч, импорт буурах боломж бүрдэнэ. -Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд хүлэмжийн аж ахуй байгуулах иргэн, аж ахуйн нэгжид 150,000-3,000,000 хүртэл долларын зээл олгож байна.	0

Зорилт 3. Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

10	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.20, 2.41, 2.47, 2.48 дахь заалт	Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох БТГ, ХХ	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	5	-	-	<p>-Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулав.</p> <p>-Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төслийн тандан судалгааны тайланг эцэслэн боловсруулав.</p> <p>-Тариалангийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан.</p> <p>-Таримал ургамлын үр сортын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлээд байна.</p> <p>-“Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад дагалдан өөрчлөх хуулийн төслүүд”-ийг УИХ-д 2018.05.04-ний өдөр өргөн мэдүүлсэн. УИХ-аас 2018 оны 05 дугаар сарын 17,18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд”-ийг хэлэлцэх эсэхийг 89,5 хувийн саналаар дэмжиж хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт бэлдэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Уг хорооноос санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Я.Содбаатараар ахлуулан байгуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгэн, 2018 оны 06 дугаар сарын 21, 22-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p>	40
11	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	30.0 Улсын төсөв	?	<p>-“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн төслийн үндэслэл, шаардлага, зорилго, зорилтын талаар холбогдох мэргэжилтнүүдийн хүрээнд 2018 оны 2 дугаар сард уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэсэн. Хөтөлбөрийн төсөлд</p>	70

	дэх заалт	анхдугаар аян"-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах Хүнсний ҮБХЗГ					<p>салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2018 оны 6 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэж байна.</p> <p>-Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 44 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу арилжааны банкны зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлэх замаар нэр бүхий 10 аж ахуйн нэгжтэй хамтран нийт 12.8 мян тн. мах бэлтгэн Улаанбаатар хот, Дархан-Уул аймгийн хүн амын хэрэгцээнд зориулан 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн зах зээл дэх үнээс 13-35 хувиар хямд худалдан борлуулж байна. 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар борлуулалтын гүйцэтгэл 67.4 хувьтай байв.</p> <p>-“MDM” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол хуурай сүү” төслийн хүрээнд 2018 оны 2-6 дугаар сард Хэнтий аймгийн Баянхутаг, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Булган аймгийн Хутаг-Өндөр суманд хуурай сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Өвөрхангай аймгийн Богд, Говь-Алтай аймгийн Эрдэнэ суманд хуурай сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт хийж байна. Төслийн хүрээнд 2018 онд нийт 30 үйлдвэр ашиглалтад оруулна.</p> <p>-НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Монголын сүүний нэгдсэн холбоо, Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран “Дэлхийн сүүний өдөр”-ийг 2018 оны 6 дугаар сарын 01-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Арга хэмжээний хүрээнд 10 мянган хүүхдэд сүүн бүтээгдэхүүн бэлэглэж, сүүний хэрэглээний ач холбогдлын талаар сурталчлан таниулав.</p>	
--	-----------	---	--	--	--	--	--	--

12	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.48 дахь заалт	Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөнгөн ҮБХЗГ	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20.0	100.0 Гадаад эх үүсвэр	0,01 (Ой модны улсын зөвлөгөө)	<p>-Үйлдвэрлэлийг санхүү зээл, хөрөнгө оруулалтаар дэмжиж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхээр ЖДҮХДС-ийн зээлд аймаг орон нутгийн нийт 63 үйлдвэр ААН-ийг хамруулав. Дэлхийн банк, Монгол банк, Хөгжлийн банктай хөтөлбөрийн санхүүжилтийн талаар хамтран ажиллаж, 700 мян. ам долларын төслийг танилцуулав. Мөн АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, Нэмүү өртөгийн сүлжээ төсөл, 2019 оны Үндсэн чиглэлд 753 тэрбум төгрөгийн санхүүжилтийн төсвийг тусгуулахаар хүргүүлсэн. Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ, Татварын багц хуулинд орох өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулах санал тусгуулав.</p> <p>-Орон нутгийн түүхий эдэд тулгуурлан шинээр байгуулах үйлдвэрийн байршлын схем зураглал гаргав. Тайлант хугацаанд Баян-Өлгий аймагт малын тэжээл, хатгамал, Хөвсгөл аймагт хуурай сүү, Дархан-Уул аймагт шингэн бордооны үйлдвэр шинээр байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Хэнтий аймгийн Баянхутаг, Сэлэнгэ аймгийн Ерөө, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дундговь аймгийн Өлзийт, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Баянхонгор аймгийн Бууцагаан, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Булган аймгийн Хутаг-Өндөр, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд хуурай сүүний үйлдвэрийн барилгын ажил хийгдэж дууссан.</p> <p>-Баянхонгор аймагт ЖДҮ-ийн инкубатор төвийг ашиглалтад оруулан, Төв аймгийн Сэргэлэн суманд “Говь” ХК жилд 2000 тн ноолуур самнах хүчин чадалтай, анхан шатны цогцолбор үйлдвэрийг байгуулахаар шав тавьж, Увс, Орхон, Говь-Алтай аймагт мал төхөөрөх үйлдвэрийн барилгын ажлыг тус тус эхлүүлсэн. Ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөнийг 06 дугаар сарын 20-ны өдөр</p>	40
----	--	--	-------------------------------	------	------------------------	--------------------------------	---	----

							БОАЖЯ, МӨМҮЭХ-той хамтран зохион байгуулав. -ӨМӨЗО-ны Сайхан талын хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн үйл ажиллагаатай танилцаж хамтын ажиллагааг эхлүүлсэн. -Гадаад дотоод худалдаа, экспортыг дэмжих чиглэлээр худалдааны хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулав.																															
13	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15, ЭЗСХ-ийн 1.2.4 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих ЖДҮХБХЗГ	Санхүүжүүлэх төслийн тоо	400	20.0 Улсын төсөв	51.8	2018 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэнд 97,8 тэрбум төгрөгийн эх үүсвэр батлагдсантай холбоотойгоор 1031 иргэн, аж ахуйн нэгжийн 1,2 их наяд төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл ирүүлсэнээс журмын шаардлага хангасан 134 төслийг шалгаруулж, зээлийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэв. Үүнд: <table border="1"> <thead> <tr> <th>Чиглэл</th> <th>ААН-ийн тоо</th> <th>Зээл, тэрбум ₮</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Барилгын материалын үйлдвэрийн био бэлдмэл</td> <td>13</td> <td>8.8</td> </tr> <tr> <td>газар тариалан</td> <td>2</td> <td>2.1</td> </tr> <tr> <td>зоорь</td> <td>21</td> <td>12.5</td> </tr> <tr> <td>МАА</td> <td>7</td> <td>3.5</td> </tr> <tr> <td>хөнгөн үйл.</td> <td>19</td> <td>11.08</td> </tr> <tr> <td>худалдаа үйлчилгээ</td> <td>20</td> <td>7.5</td> </tr> <tr> <td>хүнс үйл.</td> <td>9</td> <td>5.9</td> </tr> <tr> <td></td> <td>43</td> <td>22.5</td> </tr> <tr> <td></td> <td>134</td> <td>73.88</td> </tr> </tbody> </table> Одоогийн байдлаар 94 иргэн, аж ахуйн нэгжид 51.8 тэрбум төгрөгийг олгоод байна.	Чиглэл	ААН-ийн тоо	Зээл, тэрбум ₮	Барилгын материалын үйлдвэрийн био бэлдмэл	13	8.8	газар тариалан	2	2.1	зоорь	21	12.5	МАА	7	3.5	хөнгөн үйл.	19	11.08	худалдаа үйлчилгээ	20	7.5	хүнс үйл.	9	5.9		43	22.5		134	73.88	70
Чиглэл	ААН-ийн тоо	Зээл, тэрбум ₮																																				
Барилгын материалын үйлдвэрийн био бэлдмэл	13	8.8																																				
газар тариалан	2	2.1																																				
зоорь	21	12.5																																				
МАА	7	3.5																																				
хөнгөн үйл.	19	11.08																																				
худалдаа үйлчилгээ	20	7.5																																				
хүнс үйл.	9	5.9																																				
	43	22.5																																				
	134	73.88																																				
14	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	100.0		Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг шинэчлэн батлуулахаар төслийг боловсруулж холбогдох яамдуудаас саналыг авч нэгтгэн 2018 оны 6 дугаар сарын 13-нд ХХААХҮ-ийн сайдын	40																														

	ийн 2.15, ЭЗСХ-ийн 1.2.4 дэх заалт	дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ЖДҮХБХЗГ				зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусган Засгийн газрын хуралдаанд оруулахаар шийдвэрлэсэн.	
15	ЗГҮАХ-ийн 2.51 дэх заалт	“Монгол ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөнгөн ҮБХЗГ	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	-	<p>Ноолуур хөтөлбөрт “ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилго бүхий ноолуурын хөгжил сан байгуулах, 500 хүртэл тэрбум төгрөгийн тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох” зорилт тусгагдсаны дагуу Монгол банк, Монгол Улсын Хөгжлийн банктай хамтран ажиллаж, улмаар 2018 оны зээлийн эх үүсвэрийг Монгол банк, Хөгжлийн банкны эх үүсвэрээс бүрдүүлсэн. Хөгжлийн банкны эх үүсвэрээс үйлдвэрлэгчдэд зээл олгохоор 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр 20180313-06/070 дугаар гэрээгээр Ноолуур хөтөлбөрийн зээлийн нөхцөл тохирох гэрээ байгуулан 2018 оны эргэлтийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх ажлыг эхлүүлэв.</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд дараахь ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:</p> <p>-Ноолуур хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжилтийг хангах чиглэлээр мэргэжлийн холбоо, үйлдвэрүүд, малчид, хоршоо, ХААБ, олон улсын төсөл хөтөлбөрийг хамруулсан Ноолуур улсын зөвлөгөөнийг 2018 оны 5 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг оролцогч талуудаас авав.</p> <p>-Хөгжлийн банктай ноолуурын эргэлтийн хөрөнгийн зээл олгохоор ерөнхий нөхцөл тохирох гэрээ байгуулан нийт 34 төслийг судалгаанд авч, Говь ХК 48 тэрбум, Гоёо ХХК 30,3 тэрбум төгрөгийн зээл авсан.</p> <p>-БНХАУ-ын Баяннуур хотод “ноолуурын форумыг 2018 оны 6 дугаар сарын 4-6 өдрүүдэд</p>	40

							<p>зохион байгуулж, хамтран ажиллах санал солилцон Ноолуур хөтөлбөрийг танилцуулж, 2 улсын мэргэжлийн холбоод хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.</p> <p>-Говь ХК жилд 2000 тн ноолуур самнах хүчин чадалтай, анхан шатны үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулахаар 17 га газар авч, шав тавих ёслолыг 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хийлээ. Энэхүү бүтээн байгуулалтын хүрээнд 1000 ажилчдын орон сууцыг эхлүүлэхээр төлөвлөсөн байна.</p>	
16	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, ЗГҮАХ-ийн 2.58, ЭЗСХ-ийн 1.1.6 дахь заалт	Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх Хөнгөн ҮБХЗГ, Хүнсний ҮБХЗГ, ЖДҮХБХЗГ	Худалдан авалтын өсөлтийн хувь	10.0	-		<p>-2017 онд төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийсэн 45 төсвийн ерөнхийлөн захирагч 64 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчит 25 байгууллага 111 тэрбум, нийт 175 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрээс худалдан авсан байна.</p> <p>-Төрийн худалдан авалтанд нийлүүлэх дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдөр МҮХАҮТ, мэргэжлийн холбоодтой хамтран “Дотоодын үйлдвэрлэл-Төрийн худалдан авалт- 2018” үзэсгэлэнг зохион байгуулж, 68 үйлдвэр ААН оролцож, 74 төрийн болон төрийн өмчит байгууллагуудын төлөөлөл бүтээгдэхүүн үйлчилгээтэй танилцаж, хамтран ажиллахаар тохиролцлоо.</p> <p>Цаашид 2018 оны эхний хагас жилийн худалдан авалтын тайлан мэдээ 2018 оны III улиралд нэгтгэхээр ажиллаж байна.</p>	40
17			Нэмэгдүүлэх нэр төрлийн тоо	10	-		<p>-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан нийт бараа, бүтээгдэхүүний худалдан авалтын тайлан мэдээг нэгтгэв. Үүнд: 2017 онд ТЭЗ 45 байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд 25, нийт 70 байгууллагын худалдан авалтын тайланд анализ хийхэд нийт 275 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүн</p>	100

						<p>дотоодын үйлдвэрээс худалдан авсан байгаа нь өмнөх оны тайланд тусгасан 12 бүлгийн 101 төрлийн бараа бүтээгдэхүүнээс даруй 30 гаруй нэр төрлөөр давсан үзүүлэлттэй байна.</p> <p>Энэхүү тайланд үндэслэн “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-ын 6 бүлэг, 10 гаруй нэр төрөлд нэмэлт өөрчлөлт оруулах, тухайлбал мод, модон бүтээгдэхүүн, зам барилгын материал, төмөр хийц, бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, Бусад бүтээгдэхүүн болон шинээр тоног төхөөрөмж гэсэн ангиллыг нэмж оруулсан тогтоолын төслийг боловсруулан холбогдох байгууллагаас санал авах болон Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Бараа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дотоодын эрэлт хэрэгцээнд нийцсэн, үйлдвэрлэлийн бодит хүчин чадалд суурилсан, чанар стандартын шаардлагад нийцсэн байх зэрэг шалгуур тавин ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--